



2020 ОНЫ ХАГАС  
ЖИЛИЙН ТАЙЛАН

# DARKHAN NEKHII JSC

TRUE MONGOLIAN GENUINE LEATHER

[www.nekhii.mn](http://www.nekhii.mn)



7717-5555

# АГУУЛГА

КОМПАНИЙН ТУХАЙ  
03

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ  
07

ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ  
11

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
19

КОМПАНИЙ ЗАСАГЛАЛ  
21

## Компаний оноосон нэр

Дархан нэхий ХК

## Үйл ажиллагааны чиглэл

Хонины нэхий, ямааны арьс, үхрийн ширээр боловсруулалт хийж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдаа, үйлчилгээ

## Компанийн албан ёсны хаяг Холбоо барих

Дархан-Уул аймаг, Дархан сум, Үйлдвэрийн район, Дархан нэхий ХК

Шуудангийн хаяг : Дархан- 213800

Шуудангийн хайрцаг : 901, Дархан нэхий

Утас: (976)-77175555

(976)-70378499

Факс: (976)-70373149

И-мэйл: info@nekhii.mn

Веб хуудас: www.nekhii.mn

Фэйсбүүк: Дархан Нэхий

## Компанийн удирдлага

ТУЗ-ын дарга : Э.Батсайхан

Ерөнхий захирал : Б.Мягмар-Өлзий

## Үүсгэн байгуулагдсан огноо

1972 он

## Ажилчдын тоо

385

**YAKET**<sup>®</sup>  
BY DARKHAN NEKHII



## ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид олон улсын чанар стандартын түвшинд хүрсэн, зах зээлд өрсөлдөх чадвар сайтай, арьс шир болон түүгээр хийсэн бүтээгдэхүүнийг шинэ болон шинэчилсэн технологиор үйлдвэрлэж, дотоод, гадаадын зах зээлд борлуулна.

## ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС

Дуурсах нэртэй, дуудах хүчтэй, хамгийн чанартай, хамгийн хямд Монгол бүтээгдэхүүнийг Монголчууд өөрсдөө үйлдвэрлэх


## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

- Шударга, ил тод, нээлттэй
- Хууль, дүрмийг чандлан сахиулна
- Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлнэ
- Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулна

## БИДНИЙ УРИА

Дэвшлийг хэрэгжүүлэгч, ёс зүйг эрхэмлэгч, байгальд ээлтэй компани

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ



TRUE MONGOLIAN GENUINE LEATHER

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

# ДАРХАН НЭХИЙ ХК

ХҮНИЙ НӨӨЦ, ЦАЛИН ХӨЛС



## Нэхий Таннери ХХК

Арьс шир боловсруулах үйлдвэрлэл



## Нэхий Гармент ХХК

Гутал, хувцас оёдлын үйлдвэрлэл



## Як Трейд ХХК

Үйлдвэрлэл, худалдаа



## Нэхий Трейд ХХК

Сүлжээ дэлгүүр, худалдаа үйлчилгээ



## Гранд Як ХХК

Түрээс & Үйлчилгээ



## Дэвжих Нэхий ХХК

Зээлийн үйлчилгээ



## Нэхий Агр ХХК

Хоол үйлдвэрлэл & Үйлчилгээ



2020 оны хагас жилийн байдлаар 385 ажилтантай үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд **COVID-19** эдийн засгийн энэхүү хүнд цаг үед ажлын байраа хадгалсан.

Хагас жилийн цалингийн дундаж 34 хувь буурсан үзүүлэлтэнд үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарт 3,4 сард гарсан COVID –н **онцгой нөхцөл** байдалтай шууд холбоотой.



“Нэхий Хотхон – 4 ээлжийн 80-н айлын 10 давхар барилгыг ашиглалтанд оруулж , гаднах хүүхдийн тоглоомын талбай, гэрэлтүүлэгийг шийдвэрлэж нийгмийн асуудалд анхаарч, ажилчиддаа хөнгөлттэй нөхцөлөөр орон сууцтай болох боломжоор хангав.



ЗГ-ын ЖДҮ-ийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд улсын хэмжээнд 6 цэг нээж, 200 гаруй хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон жижиг үйлдвэрлэгчдийг хямд үнэтэй арьс, ширээр хангаж ажиллаж байна.



COVID-19

**Covid-19** вирустэй холбоотой Улсын Онц байдлын үеэр авсан арга хэмжээ: “Гранд Як” ХХК-ийн талбайн түрээсийн төлбөрөө хоёр сараас эхлэн зургаан сарыг дуустал 30% хувиар бууруулах шийдвэрийг гаргасан. Өөрсдийн нөөц боломждоо тааруулан нийт 108 түрээслэгчиддээ 92 .6 сая төгрөгний **ХӨНГӨЛӨЛТ** үзүүлж Бизнесийн байгууллагынханд үүсч буй хүндрэлийг хохирол багатай хамт даван гарахыг бизнес эрхлэгчдэд компанийн зүгээс уриаллаа.



**МАСКАА ЗҮҮСЭН  
ТАНД БАЯРЛАЛАА**



Дархан Нэхий ХК нь бүхий л үйл ажиллагаандаа нийгмийн хариуцлагаа ухамсарлан бизнесийн үйл ажиллагаагаа ил тодоор явуулж, нийгмийн хариуцлагын өндөр ёс зүйг баримталдаг. Бид хууль, дүрмийг чандлан сахиулан байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж, хүрээлэн буй орчин болон нийгмийн сайн сайханыг чиглэсэн үйл ажиллагааг дэмжиж ажиллахаас гадна ажилтнуудынхаа ая тухтай, аюулгүй, ажиллах орчинг бүрдүүлж ажиллаж байна.

MNT'000	2018 H1	2019 H1	2020 H1
<b>Ажилтнуудын өмнө хүлээсэн үүрэг</b>	46,965	86,960	94,639
<b>Улсын өмнө хүлээсэн үүрэг</b>	443,201	429,527	463,099
<b>Нийгмийн өмнө хүлээсэн үүрэг</b>	10,049	15,700	94,172



Ажилтнуудын өмнө хүлээсэн үүрэг:

Өмнөх онтой харьцуулахад гүйцэтгэл **8.8 %** -р өссөн



Нийгмийн өмнө хүлээсэн үүрэг :

Өмнөх онтой харьцуулахад гүйцэтгэл **84 %** -р өссөн



Улсын өмнө хүлээсэн үүрэг:

Өмнөх онтой харьцуулахад гүйцэтгэл **7.8 %** өссөн

China's reform and opening-up in the past four decades is a process of gradual evolution. Former Chinese leader Deng Xiaoping described it as "crossing the river by feeling the stones".



## The Three-Step Strategy



Зардлын манлайлалыг хэрэгжүүлж, Үр ашиггүй зардлыг бууруулсан



Бүтээгдэхүүн тус бүрээр өртгийн ашигт ажиллагааг хянаж ажилласан , бараа бүтээгдэхүүнийг сегментчилэн төрөлжүүллээ.




Компаний чанарын бодлогын бичиг баримтуудыг сайжруулан боловсруулж, бүтээгдэхүүний тоо ширхэг бус , чанартай бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэл явуулахад түлхүү анхаарч ажиллаа



# СТАТИСТИК МЭДЭЭ


2019 Н1

2020 Н1



155.9  
Ш

31.4  
Ш




221.3  
Ш

185.1  
Ш



26.7  
ХОС

21  
ХОС




23.2  
Ш

20.8  
Ш

Борлуулалтын орлого MNT'000	6/30/2020	6/30/2019
Гадаад борлуулалт	112,820	1,068,858
Дотоод борлуулалт	5,834,999	6,703,218
Нийт	5,947,819	7,772,077



# ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛСЭН ШИНЭ ТЕХНОЛОГИ, ХӨГЖҮҮЛЭЛТ



## YAKET бренд

Limited edition YAKET шинэ коллекцийн кетнүүд маань -100% цэвэр арьсан, улны хувьд чийг татахгүй хугарахгүй. 2020 оны 7-р сард нэрийн барааны дэлгүүрүүд болон онлайн худалдаанд гарсан.

## HIGH CLASS BOUTIQUE

Тохижилтын ажил 90% хийгдсэн ба 2020 оны 8-р сарын 05 ний өдрөөс эхлэн үйл ажиллагаа эхэлнэ. Тус дэлгүүр нь YAK брэндийн /Limited Edition/ буюу цөөн тоогоор хийгддэг тансаг зэрэглэлийн болон YAK брэндийн /Specially made for you/ буюу тусгай захиалгаар цор ганц хийгддэг бүтээгдэхүүнүүдийг худалдан борлуулна.

## ӨВЛИЙН БОТИНК

Нэмэлт хийсэн чийг татахгүй нэхий дотортой гүйцээн боловсруулж гоёлын өнгө засал хийсэн шхрийн шир нь дээр Хятад улсын Mustang үйлдвэрийн Оросын зах зээлд нийлүүлдэг, шинэ технологийн TPR материалын эрэгтэй загварын улыг туршин үйлдвэрлэлд нэвтрүүлсэн.



## ХҮҮХДИЙН АЯГАН УЛ

2019 онд чанарлаг загварлаг бүтээгдэхүүнээрээ тэргүүлэх зорилтын хүрээнд Хятад улсын Mustang үйлдвэрийн Оросын зах зээлд нийлүүлдэг, шинэ технологийн TPU материалын аяган улыг туршин үйлдвэрлэлд нэвтрүүлж эхэлсэн.

Термопластик полиуретан буюу TPU нь туйлын уян хатан, удаан эдэлгээтэй, гал, ус, үрэлтэнд маш тэсвэртэй материал. Түүний бүтэц нь гинжин хэлхээнд холбогдсон зөөлөн, хатуу сегментээс бүрддэг тул чийг татах хальтарч хагарч хөлдөх гэсэн асуудал үүсэхгүй.

Энэхүү аяган ул нь TPU аяган ул, дотуур ул, эсгий ул, ширэн болон нэхий улавч гэсэн 5 давхаргаас бүрдэнэ.



## НЭХИЙ ДЭЭЛ

2019 оны хувьд нэхий дээлний загварын 40%-ийг хөвөрдлөгөө оёдолтс технологит шилжүүлсэн ба энэ нь үндсэн материалын хувьд бол оёдол гүйцэтгэх хугацааг богино болгож, нэгж бүтээгдэхүүн дэх бүтээмжийг 38% өсгөж өгч байгаа.



## ГРАНД ЯК ЗОЧИД БУУДАЛ **ҮҮД ХААЛГАА НЭЭЛЭЭ**




### ГРАНД ЯК ЗОЧИД БУУДЛЫН **ТАНИЛЦУУЛГА**

Гранд Як зочид буудал нь олон улсын стандартад нийцсэн, зочин хүлээн авах нийт 108 өрөөтэй орчин үеийн болон уламжлалт загвар дизайны хэв шинжийг хослуулсан зочид буудал юм.

Хоногт 173 зочин хүлээн авч үйлчлэх боломжтой ба стандарт, хагас люкс, бизнес люкс, гэр бүлийн, люкс ангилалын өрөөнүүдийг санал болгож байна. Зочдын 54 өрөө нь амралтын хүрээлэн, 54 өрөө нь төв замруугаа Дархан хотыг тольдон харсан байрлалтай.

Найрсаг үйлчилгээ болон өглөөний хоол, утасгүй интернет, стандарт өрөөнүүдэд 43 инч TV, люкс өрөөнүүдэд 51 инчийн хамгийн сүүлийн үеийн смарт TV, телефон утас, угаалгын үйлчилгээ, зочдынхоо ая тух эрүүл мэндэд зориулж цэвэр модон тавилга, зөөлөн тухтай ор, аюулгүй байдалд анхаарч хаалганы ухаалаг цоожны системийг суурилуулсан болно.


Мөн амт чанартай Европ, Монгол хоолтой ресторан, 20 хүний багтаамжтай VIP хурлын өрөө, 70 хүний багтаамжтай том хурлын өрөө, 30 хүний багтаамжтай сургалтын танхим, зочид буудлын урд талд байрлах Гранд Як бизнес төвийн 1 давхарт Хаан банк, 24 цагийн АТМ-ээр, 2 давхартаа хүүхэд залуучуудыг амралт чөлөөт цагаа өнгөрөөх дугуйт тэшүүр, фиднес аэробек, спенингийн төвөөр үйлчлүүлж болно.



Коридор хэсэг



Гадна орчин харагдах байдал



Угтах хэсэг




## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

MNT'000	2020	2021	2022	2023	2024
Борлуулалтын орлого (Цэвэр)	1,006,405	2,165,328	2,435,994	2,814,926	3,302,125
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	1,398,961	1,190,930	1,293,512	1,469,391	1,657,666
Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(392,555)	974,397	1,142,481	1,345,534	1,644,458
Орлогын татварын зардал		97,439	114,248	134,553	164,445
<b>ЦЭВЭР АШИГ</b>	<b>(392,555)</b>	<b>876,957</b>	<b>1,028,233</b>	<b>1,210,981</b>	<b>1,480,012</b>

# ШИНЭ ҮЙЛДВЭРЛЭЛ ТУН УДАХГҮЙ



ДАРХАН НЭХИЙ ХУВЬЦААТ КОМПАНИ



## Шахмал ширний үйлдвэр ТАНИЛЦУУЛГА

**Шахмал шир** гэдэг нь арьс боловсруулах үйлдвэрийн үйлдвэрлэлийн явцад бий болсон хатуу хаягдал болох түүхий эдийг өндөр даралт, цавууны тусламжтай ахин боловсруулалт хийж гаргаж авсан ширийг хэлдэг.

Олон улсад тавилга, арьсан эдлэл, буйдангийн үйлдвэрлэлд 2007 оноос хойш түлхүү хэрэглэгдэж эхэлсэн

### Төслийн ач холбогдол:

- Үр өгөөжгүй хог, хаягдалуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулна.
- Компанийн бүтээгдэхүүний тоо, ашиг орлого нэмэгдэнэ.
- Импортыг орлох сайн чанарын шахмал ширийг дотоодын зах зээлд боломжит үнээр нийлүүлнэ.
- Байгальд халгүй үйлдвэрлэл явуулах боломж бүрдэнэ.
- Хог хаягдлаа дахин боловсруулснаар түүнийг хадгалах зай талбайг багасгах улмаар тэрхүү талбайг үр ашигтай ашиглах бололцоо нээгдэнэ.

### Давуу тал:

- Жинхэнэ арьс ширтэй харьцуулахад үйлдвэрийн зардал бага, түүхий эдийн зардал бага (хог хаягдал дахин боловсруулна)
- Жинхэнэ ширтэй харьцуулахад шинж чанарын хувьд ялгаагүй
- Өө сэвгүй, гэмтэлгүй нүүртэй жинхэнэ арьс
- Өнгөний сонголт арвин
- Байгаль орчинд ээлтэй

Хаягдал ногоон зоргодос:



Хаягдал ширний захалгаа:



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

MNT'000	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
Борлуулалтын орлого (Цэвэр)	1,892,436,480	1,937,304,429	2,179,467,482	2,470,063,146	2,717,069,461
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	808,395,840	808,415,840	886,704,070	962,507,300	1,038,295,530
Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	590,998,073	682,350,132	899,929,065	1,175,269,076	1,414,947,803
Орлогын татварын зардал	59,099,807	68,235,013	89,992,906	117,526,908	141,494,780
<b>ЦЭВЭР АШИГ</b>	<b>531,898,266</b>	<b>614,115,118</b>	<b>809,936,158</b>	<b>1,057,742,168</b>	<b>1,273,453,023</b>



TRUE MONGOLIAN GENUINE LEATHER

# САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

MNT'000	2018 H1	2019 H1	2020 H1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,339,951.9	2,468,617.7	481,779.8
Дансны авлага	3,746,966.7	5,611,276.8	5,814,593.5
Бараа материал	16,499,436.5	15,436,346.0	15,879,981.3
Дуусаагүй барилга	1,775,807.9	3,390,373.7	345,575.2
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгө	1,892,565.4	3,528,893.0	2,810,550.2
Үндсэн хөрөнгө	31,140,212.1	27,788,033.8	34,829,764.7
Бусад хөрөнгө	2,330,355.9	2,566,542.0	2,979,751.3
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>58,725,296.5</b>	<b>60,790,083.1</b>	<b>63,141,996.0</b>
Дансны өглөг	4,155,532.9	2,761,884.9	4,603,177.8
Богино хугацаат зээл	366,180.0	626,981.1	1,270,602.9
<b>Урт хугацаат зээл</b>	<b>8,500,000.0</b>	<b>12,153,900.0</b>	<b>9,777,219.7</b>
Урьдчилж орсон орлого	2,454,262.0	3,243,582.2	3,177,177.9
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>15,475,974.8</b>	<b>18,786,348.2</b>	<b>18,828,178.3</b>
Хуримтлагдсан ашиг	14,944,019.5	14,706,768.8	17,030,272.7
<b>НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>28,305,302.1</b>	<b>27,296,966.1</b>	<b>27,283,544.9</b>

## ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

MNT'000	2018 H1	2019 H1	2020 H1
Борлуулалтын орлого	9,001,941	7,925,719	5,935,465
Түрээсийн орлого	88,340	357,521	294,625
Хүүний орлого	364,468	188,472	165,733
Бусад орлого	125,453	13,039	187,710
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>9,580,202</b>	<b>8,484,750</b>	<b>6,583,533</b>
<b>ЦЭВЭР АШИГ</b>	<b>152,126</b>	<b>283,769</b>	<b>276,068</b>
Ерөнхий ба удирдлага үйл ажиллагааны зардал	2,817,569	2,574,419	2,433,624
Үйлдвэрлэл болон бусад зардал	6,610,507	5,626,562	3,873,841
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>9,428,076</b>	<b>8,200,981</b>	<b>6,307,465</b>

TRUE MONGOLIAN GENUINE LEATHER

# КОМПАНИЙ ЗАСАГЛАЛ

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн одоогийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 03 сарын 23-ны өдрийн ээлжит хурлаар 2 жилийн хугацаатай сонгосон.

Ердийн гишүүдэд:

Эрдэнэдалайн Батсайхан  
Равжаагийн Сүмбэнхүү  
Далхжавын Батжаргал  
Хумбагайн Золжаргал  
Баасангийн Гэрэлмаа

Хараат бус гишүүдэд:

Бямбадашийн Мөнхбаяр  
Цэдэвсүрэнгийн Алтангэрэл  
Бат-Очирын Энхнавч  
Цагааны Баттогтох

## Аудитийн хороо

Цэдэвсүрэнгийн Алтангэрэл  
Цагааны Баттогтох  
Бямбадашийн Мөнхбаяр

## Шагнал урамшуулаллын хороо

Хумбагайн Золжаргал  
Бямбадашийн Мөнхбаяр  
Бат-Очирын Энхнавч

## Нэр дэвшүүлэх хороо

Далхжавын Батжаргал  
Цэдэвсүрэнгийн Алтангэрэл  
Бат-Очирын Энхнавч  
Цагааны Баттогтох

# УДИРДЛАГЫН БАГ



Б.МЯГМАР-ӨЛЗИЙ  
Дархан Нэхий ХК  
Гүйцэтгэх захирал



Б.ЧИНЧУЛУУН  
Нэхий Таннери ХХК  
Гүйцэтгэх захирал



З.ОЮУНТУЯА  
Нэхий Гармент ХХК  
Гүйцэтгэх захирал



А.ХАНДСҮРЭН  
Гранд ЯК ХХК  
Гүйцэтгэх захирал



Б.ГЭРЭЛМАА  
Нэхий Трейд ХХК  
Гүйцэтгэх захирал



Б.ЧАНЦАЛ  
Як Трейд ХХК  
Гүйцэтгэх захирал



Г.ГАН-ОЧИР  
Дэвжих Нэхий ХХК  
Гүйцэтгэх захирал



Д.АРИУНСАЙХАН  
Нэхий Агр ХХК  
Гүйцэтгэх захирал

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ



Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлын товч мэдээлэл:

“Дархан нэхий” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 03 сарын 21-ны өдрийн 12 цагт Дархан-Уул аймгийн Дархан сумын Үйлдвэрийн районд байрлах “Дархан нэхий” ХК-ийн өөрийн байранд 81,5% хувийн ирцтэй амжилттай зохион байгуулагдлаа.



Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 3 асуудлыг хэлэлцэж баталсан болно. Үүнд:

- Компаний дүрэмт нэмэлт өөрчлөв.
- Дархан нэхий ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлав.
- Дархан нэхий Хувьцаат Компанийн хувьцаа хуваах тухай төслийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг дэмжиж батлав.
- ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг болон 2020 оны ТУЗ-ийн нэгдсэн төсвийг тус тус батлав.

## ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Дархан Нэхий ХК нь Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд хамаардаг бөгөөд компанийн зах зээлийн үнэлгээ 15.5 тэрбум төгрөгт хүрч Монголын хөрөнгийн биржид хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй 30 компаниудад багтдаг.

**Буянт мал сүргийн  
Баялгийн эзэд болж  
" Нэхий хувьцаа " тань  
Монголын мал сүрэг шигээ  
Түм түмээрээ өсөх болтугай**

### ХУВЬЦАА ХУВААСАН ТУХАЙ

Дархан нэхий ХК-ийн 2020 оны 03 сарын 21-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар /ирц 81.5%/ хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, арилжааг идэвхжүүлэх, зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшигч нарын тоог нэмэгдүүлэх зорилгоор компанийн нэгж хувьцааг 1000 хуваах тухай асуудлыг хэлэлцэн 100% саналаар батлав.

Хувьцаа хуваах төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажил дээр "Голомт Капитал" ҮЦК, хуульчийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлж хуулийн дүгнэлт гаргах ажил дээр "Ананд Адвокатс ХНН" хуулийн фирм тус тус хамтран ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 07 сарын 08-ны өдрийн хурлаар Дархан Нэхий ХК-ийн хувьцаа хуваах асуудлыг хэлэлцэж зөвшөөрсөн шийдвэрийг гаргав. Улмаар компанийн хувьцааны арилжааг 2020 оны 07 сарын 9-нээс 08 сарын 02- ны хооронд түр зогсоож, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулан 2020 оны 08 сарын 03- ний өдрөөс эхлэн арилжааг сэргээнэ.



# ХОЛБОО БАРИХ

WE ARE AT YOUR SERVICE



## БАЙРШИЛ

Дархан-Уул аймаг, Дархан сум,  
Үйлдвэрийн район, Дархан нэхий ХК

Шуудангийн хаяг : Дархан- 213800

Шуудангийн хайрцаг : 901, Дархан  
нэхий



## И-МЭЙЛ

info@nekhii.mn

ficd@nekhii.mn



## УТАС

7717-5555

7037-8499

8804-8903



<http://nekhii.mn/>

<http://yaktrade.mn/>

